

ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
АУДИТЫН ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журам нь Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны (цаашид Хороо гэх)-ны бүрэлдэхүүн, хорооны гишүүдийг сонгох, чөлөөлөх, хорооны үйл ажиллагаатай холбогдох харилцааг зохицуулна.
- 1.2. Хороо нь компанийн нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, эдийн засгийн мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавьж, дотоод хяналтын, хөндлөнгийн аудит, аудиторын хараат бус байдлыг хангах үүргийг хэрэгжүүлж, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.
- 1.3. Хороо нь чиг үүргийнхээ хүрээнд тодорхой асуудлаар үнэлэлт, дүгнэлт гаргах, санал, зөвлөмж боловсруулах, бусад шаардлагатай асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж, шийдвэрлүүлнэ.

Хоёр. Хорооны чиг үүрэг

- 2.1. Хороо нь Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.4-д заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 2.2. Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын чиглэлээр:
  - 2.1.1. Компанийн дотоод хяналтын бодлого, үйл ажиллагаа, санхүү, хууль зүйн орчны эрсдэлийг тодорхойлох, үнэлгээ хийх.
  - 2.1.2. Компанийн дотоод хяналтыг боловсронгуй болгох санал дүгнэлт боловсруулах, хүрээг нь өргөжүүлэх.
  - 2.1.3. Дотоод хяналт, аудит, аудиторын хараат бус байдлыг хангах.
  - 2.1.4. Компанийн дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин, урамшууллыг тогтоох санал, дүгнэлт боловсруулах.
  - 2.1.5. Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах.
- 2.2. Санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр:
  - 2.2.1. Компанийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан, эдийн засгийн мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих.
  - 2.2.2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн тайлангийн үйл ажиллагаанд үнэлгээ дүгнэлт өгч, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад зөвлөмж, туслалцаа үзүүлэх.
  - 2.2.3. Төлөөлөн удирдах зөвлөлөөс даалгасан үүрэг, компанийн дотоод хяналтын үйл ажиллагааны талаар үнэлэлт, зөвлөмж гаргах.
  - 2.2.4. Их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй хэлцлийн талаар дүгнэлт гаргаж, Төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлэх.
- 2.3. Хөндлөнгийн аудит, аудитортой хамтран ажиллах чиглэлээр:

- 2.3.1. Хөндлөнгийн аудитын байгууллага, аудиторыг сонгох, түүнтэй байгуулах гэрээний нөхцөл, ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулж, санал, зөвлөмж гаргах.
- 2.3.2. Хөндлөнгийн аудиторын шалгалт, дүгнэлтээр илэрсэн зөрчил, түүний гаргасан зөвлөмж, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж үнэлгээ гаргах.

Гурав. Хороо, гишүүний эрх, үүрэг.

- 3.1. Хороо нь чиг үүргээ хэрэгжүүлэхдээ дараах эрх эдэлнэ:
  - 3.1.1. Хорооны үйл ажиллагааны чиг үүрэгтэй холбогдуулан бичиг баримт, тайлан, Тайлбар, бусад мэдээллийг танилцуулахыг компанийн ажилтнаас шаардах;
  - 3.1.2. Компанийн ажилтнаас асуулт, тайлбар, тодруулга авах;
  - 3.1.3. Хөндлөнгийн зөвлөх, мэргэжилтнээс зөвлөгөө, үйлчилгээ авах;
  - 3.1.4. Шаардлагатай бол хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулахыг шаардах;
  - 3.1.5. Журамд заасан чиг үүргийн хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөлөөс шаардсан бусад үүрэг гүйцэтгэх.
- 3.2. Хорооны гишүүний эрх, үүрэг:
  - 3.2.1. Хорооны ажил, үйл ажиллагаа, хуралд оролцож, санал өгөх, шийдвэр гаргахад таслах эрхтэй оролцох;
  - 3.2.2. Гишүүний үүрэг гүйцэтгэхэд олж авсан мэдээллийн нууцыг хадгалах;
  - 3.2.3. Хорооны шийдвэртэй холбоотой ашиг сонирхлын зөрчил, хараат бус байдалд гарах өөрчлөлтийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлд мэдэгдэх;
  - 3.2.4. Энэ журамд заасан чиг үүрэг гүйцэтгэх.

Дөрөв. Хорооны бүрэлдэхүүнийг тогтоох, гишүүнийг сонгох, чөлөөлөх

- 4.1. Хорооны бүрэлдэхүүн 3-аас доошгүй гишүүнтэй байх бөгөөд хорооны дарга гишүүдийг Төлөөлөн удирдах зөвлөлийн олонхийн саналаар сонгоно.
- 4.2. Гишүүний бүрэн эрхийн хугацаа нь Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийн хугацаатай адил байна.
- 4.3. Зөвхөн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн хорооны гишүүнээр сонгогдох эрхтэй.
- 4.4. Төлөөлөн удирдах зөвлөл нь хараат бус гишүүдийг хорооны гишүүнээр сонгох зарчмыг баримтлах бөгөөд хорооны гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь хараат бус гишүүн байна.
- 4.5. Төлөөлөн удирдах зөвлөлд гишүүнээр сонгогдсон компанийн удирдах ажилтныг уг хорооны гишүүнээр сонгохгүй.
- 4.6. Төлөөлөн удирдах зөвлөл нь хорооны гишүүнийг чөлөөлөх, бүрэлдэхүүнийг бүхэлд нь шинэчлэх эрх эдэлнэ.

Тав. Хорооны хурлын дэг, журам

- 5.1. Хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хорооны хурал байна. Хорооны хурал нь ээлжит ба ээлжит бус байна. Ээлжит хурлыг 6 сард нэг удаа хуралдуулна. Ээлжит бус хурлыг компанийн үйл ажиллагаа, шийдвэрлэх асуудлаас хамааран хэдийд ч хуралдуулж болно.
- 5.2. Хороо нь компанийн байранд хуралдах бөгөөд компани хорооны үйл ажиллагаа явуулах байр, нөхцөл, боломжоор хангана.
- 5.3. Хорооны хурлыг хорооны дарга удирдана.
- 5.4. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга хорооны нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэнэ.
- 5.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хорооны чиг үүрэгтэй холбоотой асуудал хэлэлцэхээр төлөвлөсөн бол хороо Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал болох өдрөөс 7 хоногийн өмнө хуралдана.

- 5.6. Хурлыг хорооны дарга, гишүүний санал эсвэл Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн хуралдуулна.
- 5.7. Хурлыг гишүүд биечлэн ирсэн тохиолдолд эсвэл биечлэн ирээгүй гишүүдийн бичгээр үйлдсэн зөвшөөрлийн дагуу явуулж болно.
- 5.8. Хорооны гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцно.
- 5.9. Хорооны нарийн бичгийн дарга хурал болохоос 3-аас доошгүй хоногийн өмнө хорооны гишүүдэд хурлын тов болон хэлэлцэх асуудлыг урьдчилан мэдэгдэж, хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээллээр хангана. Хурлын тов, хурлаар хэлэлцэх асуудлын тухай мэдээллийг утас, факс, цахим шуудангаар илгээнэ.
- 5.10. Хурлын тэмдэглэлийг нарийн бичгийн дарга хөтлөх бөгөөд тэмдэглэлд хуралд оролцсон гишүүд гарын үсэг зурна.
- 5.11. Хороо хэлэлцсэн асуудлаар санал, дүгнэлтээ бичгээр гаргаж, санал дүгнэлтээ Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад хүргүүлнэ. Хорооны дийлэнх гишүүдийн дүгнэлттэй санал нийлэхгүй байгаа гишүүн дийлэнхийн дүгнэлттэй хамт өөрийн дүгнэлтийг мэдүүлнэ.
- 5.12. Хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олонхийн саналаар хорооны санал, дүгнэлт, шийдвэр хүчин төгөлдөр болно.

#### Зургаа. Бусад асуудал

Энэ журмаар зохицуулахаар заагаагүй аливаа асуудлыг хууль тогтоомж, Компанийн дүрэм, журамд зааснаар шийдвэрлэнэ.

Төгсөв.